



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс барилга
хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн 2014 оны 01-01/05 дугаар актаар ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүйн улмаас ашиглалтыг нь хориглосон нийтийн орон сууцны зориулалттай барилгын жагсаалтад орсон, дахин төлөвлөн барилгажуулах төсөлд хамрагдсан, Сүхбаатар дүүрэг дэх 14 дүгээр цэцэрлэгийн баланст бүртгэлтэй нийт 167,745,695.43 (нэг зуун жаран долоон сая долоон зуун дөчин таван мянга зургаан зуун ерэн таван төгрөг дөчин гурван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Батбямба)-д даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100036